

**НИЙСЛЭЛИЙН НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН 2021-2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ХҮНИЙ НӨӨЦИЙН  
ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨРИЙН 2023 ОНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**

2023 оны 12 дугаар сарын 18

Улаанбаатар хот

№	Хөтөлбөрийн зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Биелэлт	Гүйцэтгэлийн хувь
1	2	3	4	5
1. 1.Төрийн албан хаагчдын ажлын үр дүнг сайжруулах, мэргэжил,мэргэшил, мэдлэг чадварыг эзэмших тасралтгүй хөгжүүлэх				
1	Боловсрол	1.1.1.Төрийн албан хаагчдын манлайлал, ур чадварыг дээшлүүлэх, харилцаа хандлагыг сайжруулах, ёс зүй, хариуцлагыг өндөржүүлэх	<p>Тус онд зохион байгуулагдах сургалтын төлөвлөгөөнд тусгах саналыг хэлтэс, албадаас нэгтгэн авч, 2023 оны сургалтын төлөвлөгөөг боловсруулан Газрын даргаар батлуулж, төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажилласан.</p> <p>Байгууллагын 2023 оны сургалтын төлөвлөгөөнд нийт 25 арга хэмжээ тусгагдсан бөгөөд үүнээс 22 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлсэн бөгөөд жилийн эцсийн байдлаар нийт 22 сургалт зохион байгуулагдсан байна. Үүнээс байгууллага дотооддоо зохион байгуулсан сургалт 8, нийт албан хаагчдыг хамарсан мэдээллийн цаг 2, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хүний нөөцийн хөгжлийн төвөөс зохион байгуулсан сургалт 12, цахим сургалт 6 хийгдсэн ба зохион байгуулсан нийт сургалтуудад давхардсан тоогоор 1238 албан хаагч хамрагдсан байна.</p> <p><b>Ажлын байрны ур чадвар олгох сургалт:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Хууль, эрх зүйн талаар – 50 албан хаагч</li> <li>• Стратеги, төлөвлөгөө боловсруулах арга зүй – 302 албан хаагч</li> <li>• "Алсын хараа-2050" сургалт -6 албан хаагч</li> <li>• Хөгжлийн бодлогын баримт бичгийн төлөвлөлт, тайлагналт хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй -11 албан хаагч</li> <li>• Архив, албан хэрэг хөтлөлт -15 албан хаагч</li> <li>• Төрийн байгууллагад нийтлэг хөтлөгддөг баримт бичгийг боловсруулах арга зүй -3 албан хаагч</li> <li>• Хөдөлмөрийн тухай хууль шинэчилсэн найрууллага -50 албан хаагч</li> <li>• Жендэрийн тэгш байдал албан хаагч-141 албан хаагч</li> <li>• Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, журам -264 албан хаагч</li> <li>• Монгол хэлний зөв бичих дүрэм, албан хэрэгцээнд ашиглах -50 албан хаагч</li> </ul> <p><b>Мэргэшүүлэх сургалт:</b></p> <p>Зөөгчийн анхан шатны мэдлэг олгох сургалтыг 2023 оны 07 дугаар сарын 06-ны</p>	100%

			<p>өдөр ширээ засах дүрэм, өдөр тутмын ширээ засалт, захиалгат ширээ засалт, Орос, франц, америк, швед үйлчилгээ үзүүлэх аргууд, согтоогч ундааны төрөл, үйлчлэх аргууд, шилэн эдлэлийн төрөл ангилал, төмөр эдлэлийн төрөл ангилал, дарс болон оргилуун дарсаар үйлчлэх технологи, зочинтой харьцах, ширээ цэвэрлэх, хоолоор үйлчлэх арга техникийн талаар зохион байгуулж, мэдлэг мэдээллийг олгосон.</p>	
			<p><b>Харилцаа хандлага, ур чадвар олгох сургалт:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• “Харилцан хүндэтгэе” аян -270 ажилтан, албан хаагч</li> <li>• Ээлтэй орчин бүрдүүлэх нь -50 албан хаагч</li> <li>• Ажлын байрны үр дүнтэй харилцааг удирдан манлайлах нь -4 албан хаагч хамрагдсан.</li> </ul>	100%
1	Боловсрол	1.1.2.Баримт бичиг боловсруулах, архив, албан хэрэг хөтлөх ур чадварыг сайжруулах сургалт	<p>Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хүний нөөцийн хөгжлийн төвөөс Нийслэлийн Нутгийн захиргааны байгууллагуудад төрийн албанд анх томилогдсон албан хаагчид болон шинэ томилогдсон архив, бичиг хэргийн ажилтнуудад баримт бичгийн стандарт, журмын дагуу бүрдүүлэх мэдлэг олгох “Баримт бичгийн стандарт баримт, бичгийг зохион бүрдүүлэх” сэдэвт сургалтыг 2023 оны 03 дугаар сарын 23 болон 05 дугаар сарын 11-ний өдрүүдэд зохион байгуулж, нийт 15 ажилтан, албан хаагчид хамрагдсан байна.</p>	100%
		1.1.3.Чанарын удирдлагын тогтолцоо ISO 9001 стандарт нэвтрүүлэх сургалтыг үе шаттайгаар зохион байгуулах	<p>Чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх ажлын хүрээнд 2023 оны 03 дугаар сарын 07-ны өдөр байгууллагын нийт ажилтнуудад стандартын мэдлэг олгох сургалтыг зохион байгуулсан ба нийт 8 бүлэг хичээлийн 10 багц сургалтад давхардсан тоогоор 302 ажилтан, албан хаагчид хамрагдсан.</p> <p>2023 оны 06 дугаар сарын 15-ны өдөр “ISO 9001:2016 Чанарын менежментийн тогтолцоо” нэвтрүүлэх ажлын хүрээнд аудитор бэлтгэх сертификаттай сургалтад 5 албан хаагч хамрагдсан.</p>	
		1.1.4.Монгол бичиг, монгол хэлний зөв бичих дүрэм, найруулга зүйн тухай ойлголт сургалтыг үе шаттайгаар зохион байгуулах	<p>Монгол бичгийн анхан шатны мэдлэг олгох сургалтыг 2023 оны 08 дугаар сарын 30, 09 дүгээр сарын 14-ний өдрүүдэд Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн 50 албан хаагчдад нийт 14 цагийн хичээл заахаар төлөвлөснөөс 2 цагийн танхим, 6 цагийн цахим хичээлийг зохион байгуулж мэдээлэл арга зүйгээр ханган ажилласан.</p>	100%

	<p>1.1.5. Стратеги төлөвлөгөө боловсруулах аргачлалд тавигдах шаардлага сургалт</p>	<p>Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоол, ЗГХЭГ-ын даргын 100 дугаар тушаалыг тус тус үндэслэн байгууллагын стратеги төлөвлөгөөг боловсруулахад шаардлагатай гадаад, дотоод орчныг задлан шинжилж, хэтийн зорилгыг тодорхойлох менежментийн зөвлөх сургалтыг Удирдлагын академитай хамтран 2023 оны 03 дугаар сарын 09-ний өдөр "Стратеги төлөвлөгөө боловсруулах, арга зүй" сэдвээр зохион байгуулж нийт Захиргаа, төлөвлөлт санхүүгийн хэлтсийн 4 албан хаагч хамрагдсан.</p>	
	<p>1.1.6. Төрийн үйлчилгээний албан хаагчдын ёс зүй, харьцаа хандлагыг дээшлүүлэх сургалт</p>	<p>Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хүний нөөцийн хөгжлийн төвөөс 2023 оны 05 дугаар сарын 12-ны өдөр зохион байгуулсан төрийн албан хаагч бусдыгаа үлгэрлэн манлайлан ажиллах, харилцаа, хандлага, ёс зүйн хувьд мэдрэмжтэй байж бусдыг ойлгон, ухаалгаар нөлөөлөх зэрэг дэд сэдвүүдтэй "Удирдлагын ажилтны ёс зүй" сэдэвт сургалтад Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн 4 албан хаагч хамрагдсан.</p> <p>Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хүний нөөцийн хөгжлийн төвөөс 2023 оны 08 дугаар сарын 16-ны өдөр зохион байгуулсан "Төрийн албан хаагчийн ёс зүй" сургалтад 3 албан хаагч амжилттай хамрагдсан.</p>	
	<p>1.1.7. Тогтвор суурьшил, үр бүтээлтэй ажиллаж байгаа ажилтан, албан хаагчдын мэргэшил дээшлүүлэх сургалтад сурах бололцоогоор хангаж дэмжлэг үзүүлэх</p>	<p>Тайлант хугацаанд:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Хүмүүнлэгийн Ухааны Их Сургуулийн хэл шинжлэлийн магистраар 06 дугаар сард төгсөн, үргэлжлүүлэн Удирдлагын академийн Удирдахуйн Ухааны Их Сургуульд төрийн удирдлагын докторантаар суралцаж байгаа-1 албан хаагч,</li> <li>• Шихихутаг дээд сургуулийн эрх зүйч бакалавр 05 дугаар сард төгссөн -1 албан хаагч,</li> <li>• Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хүний нөөцийн хөгжлийн төвийн "Хүний нөөцийн ажилтныг чадавхжуулах нь" гэрчилгээтэй сургалтад -1 албан хаагч,</li> <li>• "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын талаар чадавхжуулах гэрчилгээтэй сургалтад -5 албан хаагч тус тус хамрагдав.</li> </ul> <p>Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Төрийн худалдан авах ажиллагааны газраас 2023 оны 11 дүгээр сарын 22-ноос 24-ний өдрүүдэд зохион байгуулсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлэх суурь мэдлэг" олгох гэрчилгээтэй сургалтад 7 албан хаагч хамрагдав.</p>	
	<p>1.1.8. Шинээр томилогдон ажилтан, албан хаагчдад ёс</p>	<p>Шинээр томилогдсон ажилтан, албан хаагчдад байгууллагын ёс зүйн дүрэм болон холбогдох хууль тогтоомжууд, албан тушаалын тодорхойлолтод заагдсан чиг</p>	

1	зүйн дүрэм, холбогдох хууль тогтоомж, албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийг таниулах, ажлын байранд сургах сургалт зохион байгуулах	үүргийг танилцуулан ажиллаж байгаа бөгөөд зоогийн газрын ажилтнуудад зөөгчийн анхан шатны мэдлэг олгох сургалтыг 2023 оны 07 дугаар сарын 06-ны өдөр зохион байгуулсан.	100%
	1.1.9.Хууль тогтоомж, эрх зүйн баримт бичиг, шинэчлэл, стандартын талаар холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран сургалт зохион байгуулах	Нийслэлийн Засаг захиргааны 14 байршилд ажиллаж байгаа төрийн үйлчилгээний албан хаагчдад стандартын мэдлэг, ойлголт олгох сургалтын 2023 оны 03 дугаар сарын 20-25-ны өдрүүдэд зохион байгуулж сургалтад 125 төрийн албан хаагч хамрагдсан болно. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсээс 2023 оны 06 дугаар сарын 23-ны өдөр зохион байгуулсан Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын хууль, эрх зүйн ажилтнуудад зориулсан мэргэжил, мэргэшил, арга зүйн зөвлөгөө өгөх бүтэн өдрийн сургалтад тус газраас Хууль эрх зүй тогтоол шийдвэрийн биелэлт хариуцсан ажилтан болон Худалдан авах ажиллагаа, гэрээ хариуцсан ажилтан нар оролцов.	
	1.2 Удирдах албан хаагчдын манлайлалын чадварыг хөгжүүлэх		
1.2.1.Удирдах албан тушаалтануудыг төрийн албаны манлайлах ур чадварыг нэмэгдүүлэх сургалтад хамруулах	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хүний нөөцийн хөгжлийн төвөөс байгууллагын албан хаагчид өөрсдийн манлайллын ур чадвараа нэмэгдүүлэх, арга барилаа сайжруулахад дэмжлэг үзүүлэх зорилготой "Төрийн албан хаагчийн манлайлал" сэдэвт сургалтыг 2023 оны 05 дугаар сарын 05-ны өдөр зохион байгуулсан ба сургалтад байр хариуцсан менежерүүд болон угтах үйлчилгээний ажилтнууд нийт 22 албан хаагчид хамрагдав.	100%	
2.1 Төрийн албан хаагчдын эрүүл мэндийг сахин хамгаалах			
2.1.1.Жил бүр ажилтан, албан хаагчдыг нарийн мэргэжлийн эмч нарын урьдчилан сэргийлэх үзлэгт	Монгол Улсын Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/139 дүгээр тушаалаар "Хүн амын нас хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, үзлэг, шинжилгээ, оношилгоог зохион байгуулах журам"-ын дагуу байгууллагын нийт 272 ажилтан, албан хаагчдыг эрт илрүүлэг, мэндийн үзлэг, оношлогоонд хамруулах үйл ажиллагааг Хан-Уул дүүргийн Нэгдсэн эмнэлэгтэй хамтран 2023 оны 04 дүгээр сарын 13-29-ний өдрүүдэд зохион байгуулж үзлэгт 170 ажилтан, албан хаагчдыг хамруулсан нь нийт албан хаагчдын 62 хувийг эзэлж байна.		

2	Эрүүл мэнд	2.1.2. Байгууллагын биеийн тамир спортын хамтлаг нь нийтийн биеийн тамирыг сурталчлах ажилтан, албан хаагчдыг чийрэгжүүлэх, эрүүл мэндийн анхан шатны боловсрол олгох, хамт олны нөхөрлөлийг бэхжүүлэх чиглэлээр ажил зохион байгуулах	<p>Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлан хэрэгжүүлж буй "Эрүүл Монгол хүн" үндэсний хөдөлгөөн, Биеийн тамир, спортын тухай хууль, "Алсын хараа-2050" Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд "Цаг гаргая" биеийн тамирын арга хэмжээг зохион байгуулан, спорт хамтлагийн үйл ажиллагааг идэвхжүүлэн, ажилтан, албан хаагчдын идэвх сонирхлыг дэмжин 2023 оны 05 дугаар сарын 19,20-ны өдрүүдэд гар бөмбөг, сагсан бөмбөг, ширээний теннис, дартс гэсэн 4 төрлөөр нийт 263 ажилтан, албан хаагчид хамрагдаж амжилттай зохион байгуулсан.</p> <p>Нийслэлийн Засаг даргын нэрэмжит Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын спортын IV наадмын (4 дүгээр бүс) Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлагуудын аварга шалгаруулах тэмцээнд Нийтлэг үйлчилгээний газрын хамт олон идэвхтэй оролцсон бөгөөд тэмцээн нь спортын 4 төрлөөр (сагсан бөмбөг, волейбол, ажлын байрны дасгал хөдөлгөөн, дартс) зохион байгуулагдсан. Тэмцээнд Нийтлэг үйлчилгээний газрын хамт олон 4 төрөлд оролцсон бөгөөд давхардсан тоогоор нийт 48 ажилтан, албан хаагчийг хамруулан идэвхтэй оролцсон.</p>	100%
		2.1.3. Цасны баяр, явган аялалыг зохион байгуулах	<p>Монгол Улсын Биеийн тамир, спортын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалт, 10.1.2 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолын хавсралт "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 2.2.1 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт "Алсын хараа-2050" Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 3.5.1 дэх заалтыг хэрэгжүүлэх зорилгоор "Эрүүл мэндийн цахим гүйлт 2023" биеийн тамирын арга хэмжээг Нийтлэг үйлчилгээний газрын ажилтан, албан хаагчдын хэмжээнд 2023 оны 05 дугаар сарын 01-07-ны өдрүүдэд зохион байгуулан ажилласан.</p> <p>Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн биеийн тамир, спортын газар, "Хай пэймэнт солишнс" ХХК /Hipay/, Монголын хөнгөн атлетикийн холбоо хамтран зохион байгуулсан "Улаанбаатар марафон-2023" олон улсын гүйлтэд тус газрын 16 ажилтан, албан хаагч амжилттай оролцон батламж авсан.</p>	
2.2 Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх				
3	Нийгмийн баталгаа	2.2.1. Албан хаагчдыг шаардлагатай компьютер, техник хэрэгсэл тоног төхөөрөмж ажлын өрөөгөөр хангаж, мэдээллийн дотоод сүлжээний найдвартай	<p>Байгууллагаас албан хаагчдын шаардлагатай компьютер, техник хэрэгсэл, мэдээллийн дотоод сүлжээний программ хангамжийн аюулгүй ажиллагааг ханган ажилласан.</p> <p>Цэвэрлэгээ үйлчилгээний чанарыг сайжруулах үүднээс цэвэрлэгээний багаж, тоног төхөөрөмжийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, үе шаттайгаар шинэчлэлт сайжруулалтын ажлыг зохион байгуулан ажилласан.</p>	100%

2	Эрүүл мэнд	2.1.2.Байгууллагын биеийн тамир спортын хамтлаг нь нийтийн биеийн тамирыг сурталчлах ажилтан, албан хаагчдыг чийрэгжүүлэх, эрүүл мэндийн анхан шатны боловсрол олгох, хамт олны нөхөрлөлийг бэхжүүлэх чиглэлээр ажил зохион байгуулах	Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлан хэрэгжүүлж буй "Эрүүл Монгол хүн" үндэсний хөдөлгөөн, Биеийн тамир, спортын тухай хууль, "Алсын хараа-2050" Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд "Цаг гаргая" биеийн тамирын арга хэмжээг зохион байгуулан, спорт хамтлагийн үйл ажиллагааг идэвхжүүлэн, ажилтан, албан хаагчдын идэвх сонирхлыг дэмжин 2023 оны 05 дугаар сарын 19,20-ны өдрүүдэд гар бөмбөг, сагсан бөмбөг, ширээний теннис, дартс гэсэн 4 төрлөөр нийт 263 ажилтан, албан хаагчид хамрагдаж амжилттай зохион байгуулсан. Нийслэлийн Засаг даргын нэрэмжит Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын спортын IV наадмын (4 дүгээр бүс) Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлагуудын аварга шалгаруулах тэмцээнд Нийтлэг үйлчилгээний газрын хамт олон идэвхтэй оролцсон бөгөөд тэмцээн нь спортын 4 төрлөөр (сагсан бөмбөг, волейбол, ажлын байрны дасгал хөдөлгөөн, дартс) зохион байгуулагдсан. Тэмцээнд Нийтлэг үйлчилгээний газрын хамт олон 4 төрөлд оролцсон бөгөөд давхардсан тоогоор нийт 48 ажилтан, албан хаагчийг хамруулан идэвхтэй оролцсон.	100%
		2.1.3.Цасны баяр, явган аялалыг зохион байгуулах	Монгол Улсын Биеийн тамир, спортын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалт, 10.1.2 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолын хавсралт "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 2.2.1 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт "Алсын хараа-2050" Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 3.5.1 дэх заалтыг хэрэгжүүлэх зорилгоор "Эрүүл мэндийн цахим гүйлт 2023" биеийн тамирын арга хэмжээг Нийтлэг үйлчилгээний газрын ажилтан, албан хаагчдын хэмжээнд 2023 оны 05 дугаар сарын 01-07-ны өдрүүдэд зохион байгуулан ажилласан. Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн биеийн тамир, спортын газар, "Хай пэймэнт солүшнс" ХХК /Hipay/, Монголын хөнгөн атлетикийн холбоо хамтран зохион байгуулсан "Улаанбаатар марафон-2023" олон улсын гүйлтэд тус газрын 16 ажилтан, албан хаагч амжилттай оролцон батламж авсан.	
2.2 Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх				
3	Нийгмийн баталгаа	2.2.1.Албан хаагчдыг шаардлагатай компьютер, техник хэрэгсэл тоног төхөөрөмж ажлын өрөөгөөр хангаж, мэдээллийн дотоод сүлжээний найдвартай	Байгууллагаас албан хаагчдын шаардлагатай компьютер, техник хэрэгсэл, мэдээллийн дотоод сүлжээний программ хангамжийн аюулгүй ажиллагааг ханган ажилласан. Цэвэрлэгээ үйлчилгээний чанарыг сайжруулах үүднээс цэвэрлэгээний багаж, тоног төхөөрөмжийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, үе шаттайгаар шинэчлэлт сайжруулалтын ажлыг зохион байгуулан ажилласан.	100%

	аюулгүй ажиллагааг тогтмол хангах		
	2.2.2.Үйлчилгээний ажилчдад ажлын хувцас, шаардлагатай эд материалаар хангаж ажиллах	Тайлант хугацаанд захиргааны албан хаагчдын 50 ширхэг хантааз, үйлчилгээний ажилтны 102 ширхэг хувцас, зоогийн газрын үйлчилгээний ажилтны 20 ширхэг хувцсыг тус тус шинэчлэн олгож ажилласан байна. Эдгээрт: Үйлчилгээний ажилтны хувцас -11.394.060 төгрөг, зоогийн газрын ажилтнуудын хувцас -8.769.100 төгрөг, захиргааны ажилтнуудын хантааз -14.435.000 төгрөг зарцуулсан байна.	
3.1 Амьдрах орчин, нөхцөлийг сайжруулах			
	3.1.1.Ажилтан, албан хаагчдын өргөдөл хүсэлтийг үндэслэн төрийн байгууллагад ажилласан хугацаа, ажлын үр дүн, амьдралын нөхцөл байдал зэргийг харгалзан хөнгөлөлттэй зээл тусламж, орон сууцжуулах хөтөлбөр, хөнгөлөлтөд хамруулах	Нийслэлийн Нутгийн захиргааны байгууллагуудын ажилтан, албан хаагчдын орон байрны нөхцөлийн судалгааны дагуу түрээслээд өмчлөх хэлбэрийн орон сууцны хөтөлбөрт хамрагдах сонирхолтой ажилтан, албан хаагчдын судалгааг гарган Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт 2023 оны 1 болон 3 дугаар сард хүргүүлэн ажилласан.	100%
	3.1.2.Ажилтан, албан хаагчдад хоол, унааны зардлын зохих хэсгийг олгох	2023 оны 4 дүгээр улирлын байдлаар нийт ажилтан, албан хаагчдад хоолны зардал, унааны хөнгөлөлтөд нийт 1.478.745.900 төгрөгийг олгон ажилласан.	100%
3.2 Төрийн албан хаагчид үзүүлэх урамшуулал, тусламж, тэтгэмж			
	3.2.1.Өндөр насны тэтгэвэрт гарч буй ажилтан, албан хаагчдад Засгийн газрын 2019 оны 07 дугаар тогтоолын дагуу нэг удаагийн буцалтгүй тусламж олгох	Тайлант хугацаанд байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын дагуу буцалтгүй тусламжийг 1 ажилтанд 1.000.000 төгрөг, нас барсны тэтгэмж 11 хүнд 3.300.000 төгрөг олгосон байна. Мөн 1 удаагийн тэтгэмжид 16.998.000 төгрөг, үүнээс Цагаан сарын баяр болон ахмадын баяраар өндөр настанд 10.650.000 төгрөг тус тус зарцуулсан байна.	100%
	3.2.2.Ажилтан, албан хаагчдын гэр бүлийн гишүүн (эхнэр, нөхөр, хүүхэд, эцэг, эх) нас барсан тохиолдолд нэг удаагийн буцалтгүй тусламж олгох	Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын дагуу буцалтгүй тусламжийг 2 ажилтанд 1.500.000 төгрөг, нас барсны тэтгэмж 11 хүнд 3.300.000 төгрөгийн буцалтгүй тусламж олгосон.	
	3.2.3.Ажлын бүтээмж, үр дүнг	Ажилтан албан хаагчдын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг хагас, бүтэн	


3	холбогдох журмын хүрээнд улирал бүр үнэлж дүгнэн ур чадварын нэмэгдэл, үр дүнгийн урамшуулал олгох	жилээр дүгнэн нийт 946.987.100 төгрөгийн нэмэгдэл цалин олгосон байна.	
Нийгмийн баталгаа	3.2.4.Эрхэлсэн ажилдаа идэвх зүтгэл гаргаж үүргээ бүрэн биелүүлж амжилт гаргасан ажилтан, албан хаагчдыг шагнаж урамшуулах, төрийн дээд одон медаль бусад шагналд тодорхойлох	Монгол Улсын Нийслэл Улаанбаатар хот үүсэн байгуулагдсаны түүхт 384 жилийн ой, Нийтийн аж ахуйн үйлчилгээний салбар үүсэж хөгжсөний 92 жилийн ой, Санхүүгийн алба үүсэж хөгжсөний 112 жилийн ойн баярыг тохиолдуулан тус газарт тогтвор суурьшилтай, үйлчилгээний салбарт олон жил идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажиллаж байгаа 27 ажилтан, албан хаагчдын ажил байдлын тодорхойлолтыг боловсруулан холбогдох газарт нь хүргүүлэн ажилласан. Үүнээс: Монгол Улсын Засгийн газар, салбар яамны шагнал – 4 албан хаагч, Монгол Улсын Засгийн газар, сангийн яамны жуух бичиг – 1 албан хаагч, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн “Хүндэт тэмдэг” – 3 албан хаагч, “Хүндэт өргөмжлөл”-өөр 3, “Хүндэт үнэмлэх” – 3 албан хаагч, Нийслэлийн Засаг даргын “Нийслэлийн тэргүүний ажилтан” тэмдэг – 2 албан хаагч, “Жуух бичиг” -5 албан хаагч, Байгууллагын “Шилдэг ажилтан” -5 ажилтан, албан хаагчид тус тус шагнуулсан байна.	100%
	3.2.5.Ажилтан, албан хаагчдын ээлжийн амралтын олговрыг хуулинд нийцүүлэн олгох	Газрын даргын 2023 оны А/05 дугаар тушаалаар баталсан ээлжийн амралтын хуваарийн дагуу 265 ажилтан, албан хаагчдад ээлжийн амралтыг биеэр нь эдлүүлсэн.	100%
	3.2.6.Ажилтан, албан хаагчдын илүү цагийн болон ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдэл хөлсийг зохих хууль, журмын дагуу тухай бүр үндсэн цалингаас нь тооцож олгох	Илүү цагийн нэмэгдэл хөлсийг зохих хууль, журмын дагуу ажилтан, албан хаагчдад нийт 261.316.854 төгрөгний нэмэгдэл хөлсийг тухай бүр олгож ажилласан.	100%
	3.2.7.Ажилтан, албан хаагчдад төрийн байгууллагад ажилласан хугацааны нэмэгдлийг тооцож олгох	Байгууллагын ажилтан, албан хаагчдын төрийн албанд ажилласан жилийн судалгааг гаргаж Засгийн газрын 2020 оны 151 дүгээр тогтоол “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”, Газрын даргын 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн А/08 дугаар тушаалын дагуу нийт 221.330.798 төгрөгийг төрийн байгууллагад ажилласан хугацааны нэмэгдлийг зохих журмын дагуу олгон ажилласан.	100%

		<p>3.2.8.Ажилтан, албан хаагчдын амьдрал ахуйд нь хүнд нөхцөл байдал үүссэн тохиолдолд дэмжлэг үзүүлэх</p>	<p>Тайлант хугацаанд ажилтан, албан хаагчдын амьдрах орчныг сайжруулж амьдралын баталгаа, ажлын тогтвор суурьшилыг хангах зорилгоор:          -Нийслэлийн Нэгдсэн үйлчилгээний төвийн Оргил салбарын ажлын өрөөний үйлчлэгч В.Бумтуяагийн гэр бүлд золгүй явдал тохиолдож түүний амьдарч байсан гэр шатаж гэнэтийн аюулд өртсөн тул түүнд байгууллагаас холбогдох хууль, журмын дагуу буцалтгүй тусламж 1.000.000 төгрөг,          -Сэлбэ дэд төвийн байр хариуцсан менежер Ц.Өнөрбилэгийн гэр бүлд золгүй явдал тохиолдож түүний амьдарч байсан гэр байгалийн гэнэтийн аюулд өртсөн тул түүнд байгууллагаас холбогдох хууль, журмын дагуу буцалтгүй тусламж 500.000 төгрөгийг тус тус буцалтгүй тусламжаар олгосон болно.</p>	<p>100%</p>
--	--	--	--	-------------

ТАНИЛЦСАН:  
 ЗАХИРГАА, ТӨЛӨВЛӨЛТИЙН  
 ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР

 Б.ЗОЛБАЯР

ХЯНАСАН:  
 ХҮНИЙ НӨӨЦИЙН  
 АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

 Т.АЗЖАРГАЛ

БИЕЛЭЛТ ГАРГАСАН  
 ХҮНИЙ НӨӨЦ, ДОТООД АЖИЛ  
 ХАРИУСАН АЖИЛТАН

 Д.АМАРЖАРГАЛ